**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дуут сумын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2025/017/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2025 он | Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Аудитор: М.Энхжаргал<br>Утас:70432545 Цахим хаяг: enkhjargalm@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.13 № 02/30

танай ____________-ны № ______________-т

ДУУТ СУМЫН СУРГУУЛИЙН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
А.СЭРЖМЯДАГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дуут сумын Сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Дуут сумын Сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сургуулийн үдийн хоол болон дотуур байрны хүнс, сургалтын хэрэглэгдэхүүний авахдаа худалдан авах ажиллагаа зарлаагүй шууд худалдан авалт хийсэн, сүү хөтөлбөрийн зарцуулаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, төсвийн зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, алдаа зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, *Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", Тухайн цалин, нэмэгдэл тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг нэмж тусгана” “Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэсэн заалтуудыг мөрдөөгүй иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна*

**Асуудлыг онцолсон хэсэг**

Дуут сумын Сургууль нь тайлант онд хөрөнгө оруулалтаар 132,574.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,400.1 мянган төгрөгийн хангамжийн материалыг хүлээн авч үнэ төлбөргүй хөрөнгөөр бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Сургуулийн бүсийг утасгүй интернэтээр хангах, цахим анги байгуулах санхүүгийн түрээсийн гэрээг 96,241.0 мянган төгрөгөөр байгуулсантай холбоотойгоор өр өссөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ сүүлийн 3 жил дараалан өсөж, 2024 онд 2 дугаар түвшинд үнэлэгдэж, урамшуулал авч багш нарын өрөөг тохижуулжээ. 17 багшаас 14 нь гүйцэтгэлийн үнэлгээгээр урамшуулал авч байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **66,631,832.77** | **237,958,579.04** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 24,095,894.22 | 185,440,933.49 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 24,095,894.22 | 185,440,933.49 |
| **33** | **АВЛАГА** | - | 250,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 250,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 42,535,938.55 | 52,267,645.55 |
| **351** | **Түүхий эд материал** | 939,162.23 | 3,295,279.23 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 264,162.23 | 2,764,279.23 |
| 35130 | Эм боох материал | 675,000.00 | 531,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 41,596,776.32 | 48,972,366.32 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 4,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | - | 938,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,902,010.00 | 8,021,950.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 34,694,766.32 | 40,007,916.32 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,476,260,474.61** | **1,587,258,481.25** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,476,260,474.61 | 1,587,258,481.25 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,443,335,974.45 | 1,554,446,481.25 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,360,367,003.00 | 1,369,367,003.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (148,640,239.19) | (190,434,840.83) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 147,954,652.00 | 288,042,097.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (24,691,167.20) | (87,782,538.76) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 116,171,624.00 | 210,595,141.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (30,215,334.93) | (57,729,816.93) |
| 39217 | Ном | 22,369,436.77 | 22,369,436.77 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 32,924,500.16 | 32,812,000.00 |
| 39301 | Програм хангамж | 685,000.00 | 685,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (572,499.84) | (685,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 32,812,000.00 | 32,812,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,542,892,307.38** | **1,825,217,060.29** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **71,997,000.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 71,997,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,542,892,307.38** | **1,753,220,060.29** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,542,892,307.38 | 1,753,220,060.29 |
| 51101 | Өмч: - төрийн | 253,601,582.00 | 253,601,582.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 961,187,648.23 | 1,171,515,401.14 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 961,187,648.23 | 961,187,648.23 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 210,327,752.91 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 328,103,077.15 | 328,103,077.15 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,542,892,307.38** | **1,825,217,060.29** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,215,898,919.02** | **1,932,821,279.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **146,655,771.02** | **138,018,279.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 146,655,771.02 | 138,018,279.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 146,655,771.02 | 138,018,279.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 931,900.00 | 1,043,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 145,223,871.02 | 136,975,079.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,069,243,148.00** | **1,794,803,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 904,829,700.00 | 1,528,719,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 904,829,700.00 | 1,528,719,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 150,648.00 | 18,681,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 17,681,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 150,648.00 | 1,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 164,262,800.00 | 247,402,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 164,262,800.00 | 247,402,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,132,975,513.16** | **1,722,493,526.09** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,132,975,513.16** | **1,722,493,526.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,114,158,613.16 | 1,672,264,656.01 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 712,532,991.00 | 1,023,506,821.00 |
| 210101 | Үндсэн цалин | 487,344,497.00 | 618,342,455.00 |
| 210102 | Нэмэгдэл | 197,257,081.00 | 355,372,816.00 |
| 210104 | Урамшуулал | 27,931,413.00 | 49,791,550.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 89,290,799.78 | 172,446,615.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,233,107.69 | 90,433,161.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,177,349.51 | 52,046,654.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,737,479.45 | 4,994,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,376,616.42 | 4,994,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,766,246.71 | 19,977,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 155,244,269.45 | 225,893,739.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,353,642.45 | 9,919,921.92 |
| 210302 | Түлш, халаалт | 149,890,627.00 | 215,973,818.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 57,545,240.00 | 67,520,750.00 |
| 210502 | Хоол, хүнс | 57,545,240.00 | 67,520,750.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,774,530.55 | 1,267,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,774,530.55 | 1,267,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,152,400.00 | 11,890,914.73 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 931,900.00 | 3,662,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,220,500.00 | 8,228,114.73 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 86,618,382.38 | 169,738,315.36 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,055,920.00 | 31,308,770.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,941,300.00 | 5,916,590.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 65,621,162.38 | 132,512,955.36 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 18,816,900.00 | 50,228,870.08 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,816,400.00 | 30,919,910.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,816,400.00 | 21,296,410.00 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | - | 962,355.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 8,661,145.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 500.00 | 19,308,960.08 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 500.00 | 19,308,960.08 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **82,923,405.86** | **210,327,752.91** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **82,923,405.86** | **210,327,752.91** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,070,675,048.00** | **1,795,846,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,431,900.00** | **1,043,200.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 931,900.00 | 1,043,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,069,243,148.00** | **1,794,803,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 904,829,700.00 | 1,528,719,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 904,829,700.00 | 1,528,719,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 150,648.00 | 18,681,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 17,681,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 150,648.00 | 1,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 164,262,800.00 | 247,402,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 164,262,800.00 | 247,402,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,070,036,331.78** | **1,634,501,160.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,070,036,331.78** | **1,634,501,160.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,045,685,431.78** | **1,584,867,300.65** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 711,133,929.78 | 1,023,756,821.00 |
| 210101 | Үндсэн цалин | 485,457,620.00 | 618,592,455.00 |
| 210102 | Нэмэгдэл | 197,320,423.78 | 355,372,816.00 |
| 210104 | Урамшуулал | 28,355,886.00 | 49,791,550.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,702,082.00 | 172,446,615.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,873,282.00 | 90,433,161.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,207,200.00 | 52,046,654.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,765,900.00 | 4,994,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,441,700.00 | 4,994,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,414,000.00 | 19,977,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 155,244,269.45 | 225,893,739.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,353,642.45 | 9,919,921.92 |
| 210302 | Түлш, халаалт | 149,890,627.00 | 215,973,818.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 45,949,200.00 | 69,614,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 45,949,200.00 | 69,614,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,018,030.55 | 2,200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,018,030.55 | 2,200,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,152,400.00 | 17,567,552.14 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 931,900.00 | 3,344,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,220,500.00 | 14,223,552.14 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 31,485,520.00 | 73,388,072.59 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,654,820.00 | 67,328,672.59 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,830,700.00 | 6,059,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **24,350,900.00** | **49,633,860.08** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 24,350,400.00 | 30,324,900.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,350,400.00 | 20,641,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 9,683,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 500.00 | 19,308,960.08 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 500.00 | 19,308,960.08 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **638,716.22** | **161,345,039.27** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 638,716.22 | 161,345,039.27 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 24,095,894.22 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 24,095,894.22 | 185,440,933.49 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **253,601,582.00** | **328,103,077.15** | **961,187,648.23** | 1,542,892,307.38 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **253,601,582.00** | **328,103,077.15** | **961,187,648.23** | 1,542,892,307.38 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 210,327,752.91 | 210,327,752.91 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **253,601,582.00** | **328,103,077.15** | **1,171,515,401.14** | **1,753,220,060.29** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

## Дуут сумын Сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1819898300.00 | 1615192200.65 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1819898300.00 | 1615192200.65 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1786336000.00 | 1584867300.65 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1209728100.00 | 1023756821.00 |
| 210101 | Үндсэн цалин | 814251100.00 | 618592455.00 |
| 210102 | Нэмэгдэл | 371431100.00 | 355372816.00 |
| 210104 | Урамшуулал | 24045900.00 | 49791550.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 151216100.00 | 172446615.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 102826800.00 | 90433161.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12097300.00 | 52046654.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6048700.00 | 4994600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6048700.00 | 4994600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24194600.00 | 19977600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 245202700.00 | 225893739.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11204900.00 | 9919921.92 |
| 210302 | Түлш, халаалт | 232120600.00 | 215973818.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1877200.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 82,295,700.00 | 69,614,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 82,295,700.00 | 69,614,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,200,000.00 | 2,200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,200,000.00 | 2,200,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,314,500.00 | 17,567,552.14 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,078,300.00 | 3,344,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 14,236,200.00 | 14,223,552.14 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 75,378,900.00 | 73,388,072.59 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 69,319,500.00 | 67,328,672.59 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,059,400.00 | 6,059,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 33,562,300.00 | 30,324,900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 33,562,300.00 | 30,324,900.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 23,938,800.00 | 20,641,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,623,500.00 | 9,683,500.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,796,122,500.00 | 1,776,537,239.92 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,528,719,100.00 | 1,528,719,100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,528,719,100.00 | 1,528,719,100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 247,402,700.00 | 228,093,739.92 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 247,402,700.00 | 228,093,739.92 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 20,000,700.00 | 19,724,400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 499,500.00 | 1,043,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 19,501,200.00 | 18,681,200.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **24,095,894.22** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **185,440,933.49** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 41.00 | 39.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 23.00 | 21.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 17.00 | 17.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 210.00 | 205.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | | |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1.00 | 1.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **39.00** | **39.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 22.00 | 22.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | 1.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 16.00 | 16.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 138,447.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс залруулагдаагүй 138,447.5 мянган төгрөгийн 4 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай ” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 138,447.5 мянган төгрөгийн 4 зөрчил[1] илэрснээс, 1,916.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 136,531.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант онд хэрэглэсэн сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй 1,086.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төлбөрийн акт тогтоосон

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### *3.2.1 Зардлын данстай холбоотой асуудал*

*<u>Илрүүлэлт</u>:* Боловсролын тэргүүний ажилтан цол тэмдэг болон боловсролын жуух бичгээр шагнагдсан хүмүүст сайдын тушаалаар батлагдсан журам баримтлан мөнгөн шагнал олгосон, ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн

[1] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

үнэлгээнд үндэслээгүй, амжилтын түвшнийг харгалзан үзэлгүйгээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 1.7-д "Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй", Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35 / А/10 / 9 дүгээр "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" тушаалын 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 болон 10 дугаар зүйлтэй нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдуулан олгохгүй байх, ур чадварын нэмэгдлийг тушаалд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж холбогдох түвшинд харгалзах хувиар олгох.

### 3.3.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт: Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө, зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;'' гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж: Хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг үнэн зөв байршуулан Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах*

### 3.3.2 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт: Тайлант онд дотуур байр болон бага ангийн сурагчдын үдийн хоол хүнсэнд 133,105.8 мянган төгрөгийн материалын шууд гэрээ байгуулсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж:* Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоосон тогтоолын дагуу босго үнээс давсан барааг худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 *Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* — */мянган төгрөгөөр/*

| Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлээгүй | 1 | 1,916.0 | 1 | 1,916.0 | | | | | | |
| Боловсролын тэргүүний ажилтан цол тэмдэг болон боловсролын жуух бичгээр шагнагдсан хүмүүст сайдын тушаалаар батлагдсан журам баримтлан мөнгөн шагнал олгосон, ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд үндэслээгүй, ажилтын түвшнийг харгалзан үзэлгүйгээр олгосон | 1 | 3,425.7 | | | | | 1 | 3,425.7 | | |
| **ДҮН** | **2** | **5341.7** | **1** | **1916.0** | | | **1** | **3425.7** | | |

### 6.2 *Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал* — */мянган төгрөгөөр/*

| Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, эмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлээгүй | 1 | | | | | | 1 | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүнс, бичиг хэрэг сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж худалдан авахдаа тендер шалгаруулалт зарлаагүй | 1 | 133,105.8 | | | | | 1 | 133,105.8 |
| **ДҮН** | **2** | **133105.8** | | | | | **2** | **133105.8** |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН.**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР** **.БОЛДБААТАР**

**2025.02.13**

**АУДИТЫН МЕНЕЖЕР** **А.ЦЭЦЭГСҮРЭН**

**2025.02.13**

**БЭЛТГЭСЭН:**

**АУДИТОР** **М.ЭНХЖАРГАЛ**

**2025.02.13**

8417143682
ПЮА0073 9066454